



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/417

Ховд

┌ Жуух бичгээр шагнах тухай ─┐

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е”, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Прокурорын байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, үүрэгт ажилдаа хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлэн, Улсын Ерөнхий прокуророос дэвшүүлсэн бодлого, зорилтуудыг нэгжид ханган биелүүлэх, хяналтын ажлын чанар, үр дүнг сайжруулахад хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажиллаж байгаа прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга Д.Ганчимэг, прокурорын газрын Прокурорын туслах ажилтан Ц.Батзаяа, прокурорын жолооч Д.Буянбат, Булган сум дахь Сум дундын прокурорын жижүүр-галч Д.Батбаяр нарыг Прокурорын байгууллагын түүхт 90 жилийн ойг тохиолдуулан аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Д.Ганчимэг, Ц.Батзаяа, Д.Буянбат, Д.Батбаяр нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх /Б.Гантулга/-д зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Т.ЖАРГАЛСАЙХАН

